



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ӨВА-2022/152/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2022 он	Тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253      Цахим хаяг: <a href="mailto:atjargalo@audit.gov.mn">atjargalo@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833      Цахим хаяг: <a href="mailto:gansukh.audit@gmail.com">gansukh.audit@gmail.com</a> Аудитор:              Ө.Ринчинмядаг Утас: 70323108      Цахим хаяг: <a href="mailto:rinchinmyadagu@audit.gov.mn">rinchinmyadagu@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	13
3.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	13
3.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	14
3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	14
3.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	15
3.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	16
3.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	16
3.11 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	16
3.12 Шилэн дансны мэдээлэл.....	17
3.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.14 Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

## 1.Аудитын гэрчилгээ



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022 о.27 № 27  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАРХОРИН СУМЫН 1-Р  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ц.БААСАНСҮРЭН ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

015030154

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4


Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О. БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	33,035,816.00	30,077,201.00
33	АВЛАГА	167,100.00	-
33500	Бусад авлага	167,100.00	-
33510	Байгууллагаас авах авлага	167,100.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	32,868,716.00	30,077,201.00
35100	Түүхий эд материал	-	216,936.00
35130	Эм боох материал	-	216,936.00
35400	Хангамжийн материал	32,868,716.00	29,860,265.00
35410	Бичиг хэргийн материал	327,400.00	211,100.00
35420	Аж ахуйн материал	1,376,800.00	1,849,900.00
35450	Барилгын засварын материал	4,451,600.00	1,248,000.00
35460	Хүнсний материал	913,950.00	1,836,465.00
35470	Бусад хангамжийн материал	25,798,966.00	24,714,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	908,797,884.59	881,446,935.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	908,797,884.59	881,446,935.25
39200	Биет хөрөнгө	807,849,134.42	814,246,935.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	800,749,052.20	799,878,103.00
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	- 14,442,243.53	27,773,545.25
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	30,727,584.00	49,070,207.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	- 16,503,821.74	18,450,852.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,057,927.00	15,538,746.85
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	- 12,856,185.31	7,013,404.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,191,406.00	3,191,406.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	- 2,233,984.20	2,553,124.80
39217	Номын фонд	2,159,400.00	2,359,400.00
39300	Биет бус хөрөнгө	100,948,750.17	67,200,000.00
39301	Програм хангамж	245,000.00	245,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	- 208,249.83	245,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	100,912,000.00	67,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	941,833,700.59	911,524,136.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	941,833,700.59	911,524,136.25
51	Засгийн газрын хувь оролцоо	941,833,700.59	911,524,136.25
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	141,977,160.00	141,977,160.00
51200	Хуримтлагдсан үр дүн	799,856,540.59	769,546,976.25
51210	Өмнөх үеийн үр дүн	799,856,540.59	799,856,540.59
51220	Тайлант үеийн үр дүн	-	30,309,564.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	941,833,700.59	911,524,136.25

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	310,362,040.00	308,172,989.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	310,362,040.00	307,519,853.85
1200	Нийтлэг татварын бус орлого	7,248,500.00	33,191,153.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,248,500.00	33,191,153.85
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,248,500.00	33,191,153.85
1230	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	303,113,540.00	274,328,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	262,865,840.00	237,038,800.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	40,247,700.00	37,289,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	653,136.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	653,136.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	-	653,136.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	288,913,919.98	303,899,604.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288,913,919.98	303,899,604.99
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	287,605,109.98	299,565,158.18
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	189,365,849.00	189,880,100.00
210101	Үндсэн цалин	171,870,306.00	137,715,773.00
210102	Нэмэгдэл	-	39,422,434.00
210104	Урамшуулал	17,495,543.00	12,741,893.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,069,000.22	25,139,341.19
210201	Тэтгэврийн даатгал	16,355,759.88	17,535,741.19
210202	Тэтгэмжийн даатгал	1,931,459.96	1,900,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,541,808.47	1,520,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	385,451.99	633,660.31
210205	Эрүүл мэндийн даатгал	3,854,519.92	3,548,339.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,256,976.00	26,528,112.00
210301	Гэрэл, цахилгаан	1,906,101.00	3,094,131.00
210302	Түлш, халаалт	19,713,315.00	21,619,811.00
210303	Цэвэр, бохир ус	2,637,560.00	1,814,170.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,886,400.00	14,290,426.00
210401	Бичиг хэрэг	1,253,900.00	1,708,719.00
210402	Тээвэр, шатахуун	1,663,800.00	1,788,800.00

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,272,500.00	1,361,641.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	162,800.00	83,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,533,400.00	9,348,266.00
2105	Нормативт зардал	13,808,590.00	12,934,585.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,770.00	-
210502	Хоол, хүнс	13,699,020.00	12,934,585.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	84,800.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,636,000.00	9,502,400.00
210604	Урсгал засвар	6,636,000.00	9,502,400.00
2107	Томилолт, зочны зардал	139,500.00	139,500.00
210702	Дотоод албан томилолт	139,500.00	139,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	631,930.00	192,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	307,930.00	192,680.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,810,864.76	20,958,013.99
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	286,377.00	406,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	22,524,487.76	20,551,553.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,308,810.00	4,334,446.81
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,184,446.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,184,446.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,308,810.00	150,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,308,810.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	150,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,509,801.92	34,582,949.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	21,448,120.02	4,273,384.86
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	63,509,801.92	34,582,949.20
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	63,509,801.92	34,582,949.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	63,509,801.92	34,582,949.20
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	-	-
		42,061,681.90	30,309,564.34

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	303,113,540.00	274,981,836.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	303,113,540.00	274,328,700.00
1230	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	303,113,540.00	274,328,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	262,865,840.00	237,038,800.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	40,247,700.00	37,289,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	653,136.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	653,136.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	-	653,136.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	280,287,228.87	274,781,836.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	280,287,228.87	274,781,836.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	279,912,228.87	270,421,589.19
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	189,261,921.00	189,880,100.00
210101	Үндсэн цалин	134,449,358.00	137,715,773.00
210102	Нэмэгдэл	43,080,290.00	39,422,434.00
210104	Урамшуулал	11,732,273.00	12,741,893.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,996,395.87	25,139,341.19
210201	Тэтгэврийн даатгал	17,783,317.72	17,535,741.19
210202	Тэтгэмжийн даатгал	1,412,099.37	1,900,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,044,709.90	1,520,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	258,802.53	633,660.31
210205	Эрүүл мэндийн даатгал	3,497,466.35	3,548,339.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,256,976.00	26,528,112.00
210301	Гэрэл, цахилгаан	1,906,101.00	3,094,131.00
210302	Түлш, халаалт	19,713,315.00	21,619,811.00
210303	Цэвэр, бохир ус	2,637,560.00	1,814,170.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,987,600.00	4,539,241.00
210401	Бичиг хэрэг	195,300.00	446,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00	1,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,272,500.00	1,378,141.00
210404	Ном, хэвлэл	27,100.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	272,400.00	83,000.00

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,920,300.00	1,531,400.00
2105	Нормативт зардал	12,059,040.00	15,057,736.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,800.00	1,032,936.00
210502	Хоол, хүнс	11,584,740.00	13,690,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	418,500.00	334,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,220,500.00	6,600,000.00
210604	Урсгал засвар	11,220,500.00	6,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	139,500.00	139,500.00
210702	Дотоод албан томилолт	139,500.00	139,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	775,400.00	239,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	451,400.00	239,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,214,896.00	2,297,659.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	175,800.00	175,800.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	6,039,096.00	2,121,859.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	375,000.00	4,360,246.81
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,184,446.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,184,446.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	375,000.00	175,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	375,000.00	175,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	22,826,311.13	200,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,646,904.00	200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,646,904.00	200,000.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	3,646,904.00	200,000.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,646,904.00	200,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	19,179,407.13	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,179,407.13	-

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгэний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
8	ҮЛДЭГДЭЛ	141,977,160.00	-	799,856,540.59	-	941,833,700.59
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	141,977,160.00	-	799,856,540.59	-	941,833,700.59
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	30,309,564.34	-	30,309,564.34
16	ҮЛДЭГДЭЛ	141,977,160.00	-	769,546,976.25	-	911,524,136.25

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	302184700.00	283934132.87	274328700.00	270144253.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	302184700.00	283934132.87	274328700.00	270144253.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	301809700.00	283559132.87	274152900.00	269968453.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192944200.00	189261921.00	189880100.00	189880100.00
210101	Үндсэн цалин	118363000.00	134449358.00	133838300.00	137715773.00
210102	Нэмэгдэл	57675600.00	43080290.00	44358600.00	39422434.00
210104	Урамшуулал	16905600.00	11732273.00	11683200.00	12741893.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27898700.00	23996395.87	24838000.00	25139341.19
210201	Тэтгэврийн даатгал	19632400.00	17783317.72	17234100.00	17535741.19
210202	Тэтгэмжийн даатгал	2066600.00	1412099.37	1900800.00	1900900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1653300.00	1044709.90	1521700.00	1520700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	413300.00	258802.53	380200.00	633660.31
210205	Эрүүл мэндийн даатгал	4133100.00	3497466.35	3801200.00	3548339.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29027200.00	24256976.00	30689900.00	26528112.00
210301	Гэрэл, цахилгаан	3030500.00	1906101.00	3030800.00	3094131.00
210302	Түлш, халаалт	20311000.00	19713315.00	21973600.00	21619811.00
210303	Цэвэр, бохир ус	5685700.00	2637560.00	5685500.00	1814170.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12028900.00	12097200.00	4653000.00	4653000.00
210401	Бичиг хэрэг	265500.00	195300.00	195300.00	446700.00
210402	Тээвэр, шатахуун	1300000.00	1300000.00	1100000.00	1100000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1272500.00	1272500.00	1272500.00	1378141.00
210404	Ном, хэвлэл	136700.00	136700.00	136700.00	113759.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	272400.00	272400.00	167400.00	83000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8781800.00	8920300.00	1781100.00	1531400.00
2105	Нормативт зардал	18234600.00	12059040.00	14404600.00	14404600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55800.00	55800.00	379800.00	379800.00
210502	Хоол, хүнс	17760300.00	11584740.00	13690000.00	13690000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	418500.00	418500.00	334800.00	334800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11220500.00	11220500.00	6600000.00	6600000.00
210604	Урсгал засвар	11220500.00	11220500.00	6600000.00	6600000.00

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	139500.00	139500.00	139500.00	139500.00
210702	Дотоод албан томилолт	139500.00	139500.00	139500.00	139500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	563900.00	775400.00	563900.00	239900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	239900.00	451400.00	239900.00	239900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000.00	324000.00	324000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9752200.00	9752200.00	2383900.00	2383900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	175800.00	175800.00	175800.00	175800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9576400.00	9576400.00	2208100.00	2208100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	375000.00	375000.00	175800.00	175800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	375000.00	375000.00	175800.00	175800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	375000.00	375000.00	175800.00	175800.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	653136.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	653136.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	653136.00
2105	Нормативт зардал	0.00	653136.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	653,136.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	653136.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	653136.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	653,136.00

### **3.Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга С.Дуламрагчаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

#### **3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9.1 -д заасны дагуу Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2022.01.20-ноос 2022.01.24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.01.24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ө.Ринчинмядаг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.13-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **3.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, ААБ-3.2 маягтаар баримтжуулж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ААБ-3.1 маягтаар баталгаажуулсан болно.

Тус байгууллага нь дараах чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Цэцэрлэгт 2-5 насны хүүхдэд зөв хүн болох суурь хүмүүжил, төлөвшлийг олгож, сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах.
- Таван настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулах.
- Хүүхэд хамгааллын бодлогыг чанартай хэрэгжүүлж, олон нийт, иргэдтэй хамтран ажиллаж үр дүнд хүрэх.
- Үйл ажиллагааны мэдээ, тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж ил тод байдлыг ханган ажиллах.

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх хууль, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

### **3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл

ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Ахplorer" программ хангамж ашигладаг байна.

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт дунд гэж үзлээ.

### **3.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Хархорин сумын 1-р цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг ААБ-3.6 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг ААБ-3.7 маягтаар тус тус баримтжуулав.

### **3.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлт болгон сонголоо.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 3.038 сая төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Мөн санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 2.43 сая төгрөгөөр тогтоолоо.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг ААБ-3.5, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг ААБ-4.2 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### **3.8 Аудитын үр өгөөжийн тооцоолол**

Нэг удаагийн тэтгэмж; нормын хувцас, зөөлөн эдлэл; бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж; хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас нийт 355.0 мянган төгрөгөөр бараа материал худалдан авч оны шилдэг ажилтан шагнаж зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлагын дагуу үр өгөөж тооцов.

### 3.9 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30.3 сая төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр	2020 оны эхний үлдэгдэл	2021 оны эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,035,816.00	30,077,201.00	-2,958,615.00	-9.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00	0.00	0.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00	0.00	0.00
33	АВЛАГА	167,100.00	-	-167,100.00	100.0
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,868,716.00	30,077,201.00	-2,791,515.00	-8.5
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	908,797,884.59	881,446,935.25	27,350,949.34	-3.0
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	908,797,884.59	881,446,935.25	27,350,949.34	-3.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	941,833,700.59	911,524,136.25	30,309,564.34	-3.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00	0.00	0.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	941,833,700.59	911,524,136.25	30,309,564.34	-3.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	941,833,700.59	911,524,136.25	30,309,564.34	-3.2

### 3.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тус газар нь өөрийн орлого байхгүй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 274.3 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 274.3 сая төгрөгөөр санхүүжигдэн, 274.3 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны захирагчаас 0.65 сая төгрөгийн санхүүжилт нэмэлтээр авч эм, бэлдмэл худалдан авахад зарцуулжээ.

### 3.11 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ААБ-5.5 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	(мян төгрөгөөр)	
			Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	355.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	5	355.0	

Зориулалт бусаар зарцуулсан 355.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### 3.12 Шилэн дансны мэдээлэл

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус газар нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 149 мэдээллийг байршуулахаас 149 мэдээллийг олон нийтэд мэдээлсэн боловч 13 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

### 3.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Тухайн байгууллын 2021 оны санхүүгийн тайланд Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон постод гарсан албан хаагчдад илүү цаг өгсөнтэй холбоотойгоор 0.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн. Зөрчлийг арилгаж ажилласан байна.

### 3.14 Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад асуудал байхгүй байна.

### 3.15. Аудитын илрүүлэлт

Аудитаар харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээ, гэрээний биелэлт, анхан шатны баримтын бүрдэл, дотоод хяналттай холбоотой зөвлөмжүүд өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар залруулах алдаа илрээгүй болно.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн зөвлөмжийг менежментийн захидалд тусгав.

**Асуудал 1: Шилэн данс**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ТАГ-ын ажиглалт**

Шилэн дансны цахим хуудаст нийт 13 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:" гэж заасныг зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал алдагдах.

**ТАГ-ын зөвлөмж**

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулах.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

**Асуудал 2: Хоол, хүнс**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ТАГ-ын ажиглалт**

Хүнс нийлүүлэгч гэрээтэй харилцагч байгууллагууд гэрээнд тусгасан үнийн саналаас илүү үнээр хүнс нийлүүлсэн. Үнийн өөрчлөлт гарч болох талаар заалт гэрээнд тусгаж өгөөгүй байна.

Энэ нь 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр бараа нийлүүлэх гэрээний 3 дугаар "Нийлүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлага" зүйлийн 3.6-д "Барааны үнэ, төрөл, тоо хэмжээ, норм, чанарыг гэрээнд заасны дагуу бүрэн нийлүүлэх" гэж заасан заалтыг зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

Хөрөнгө шамшигдах.

**ТАГ-ын зөвлөмж**

Харилцагч болон нийлүүлэгч талаас гэрээнд заасан үүрэг, хариуцлагыг бүрэн хэрэгжүүлэх, гэрээний үүргийн биелэлтийг анхаарч ажиллах

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

**Асуудал 3: Хоол, хүнс**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ТАГ-ын ажиглалт**

Харилцагч байгууллагуудтай гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан

**ТАГ-ын зөвлөмж**

Харилцагч байгууллагуудтай гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ баталгаажуулж байх.

сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана." гэж заасныг зөрчсөн байна.

#### **Эрсдэлүүд**

Ашиг сонирхлын зөрчил үүсэх.

#### **Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

#### **Асуудал 4: Анхан шатны баримт**

#### **Тэргүүлэх ач холбогдол №1**

##### **ТАГ-ын ажиглалт**

Хүнсний тайлангийн анхан шатны баримт дээр засвар хийсэн, үнийн дүнг зөрүүлж бичсэн байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана." гэж заасныг зөрчсөн байна.

##### **Эрсдэлүүд**

Дотоод хяналт сул байгаагаас үүдэлтэй санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

##### **ТАГ-ын зөвлөмж**

Анхан шатны баримтын хөтлөлтийг журмын дагуу хийх, дотоод хяналтыг сайжруулах.

##### **Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

**4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: <b>2021</b>	Аудитын нэр: <b>Хархорин сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>ӨВА-2022/152/НА-СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Хархорин сумын 1-р цэцэрлэг</b>	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянга/	Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нэг удаагийн тэтгэмж; нормын хувцас, зөөлөн эдлэл; бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж; хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас нийт 355.0 мянган төгрөгөөр бараа материал худалдан авч оны шилдэг ажилтан шагнаж зардлыг зориулалт бусаар зарцуулсан.	355.0	Албан шаардлага өгсөн	Дарга, Нягтлан бодогч	Ц.Баасансүрэн, П.Доржпүрэв
2	Шилэн дансны цахим хуудаст нийт 13 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	0	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Ц.Баасансүрэн, П.Доржпүрэв
3	Хүнс нийлүүлэгч гэрээтэй харилцагч байгууллагууд гэрээнд тусгасан үнийн саналаас илүү үнээр хүнс нийлүүлсэн. Үнийн өөрчлөлт гарч болох талаар заалт гэрээнд тусгаж өгөөгүй байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Ц.Баасансүрэн, П.Доржпүрэв
4	Харилцагч байгууллагуудтай гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Ц.Баасансүрэн, П.Доржпүрэв
5	Хүнсний тайлангийн анхан шатны баримт дээр засвар хийсэн, үнийн дүнг зөрүүлж бичсэн байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Ц.Баасансүрэн, П.Доржпүрэв
<b>ДҮН</b>		355.0			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ө.РИНЧИНМЯДАГ

2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар СВА-2022/152/НА-СТА-ТМБ/11570353/45 Арвайхээр

Хархорин сумын 1-р цэцэрлэгийн  
Эрхлэгч Ц.Баасансүрэн танаа  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэг удаагийн тэтгэмж; нормын хувцас, зөөлөн эдлэл; бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж; хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас нийт 355.0 мянган төгрөгөөр бараа материал худалдан авч оны шилдэг ажилтан шагнаж зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5.-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хархорин сумын 1-р цэцэрлэгийн эрхлэгч Ц.Баасансүрэн, нягтлан бодогч П.Доржпүрэв нарт даалгав.<sup>1</sup>

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ  
АУДИТОР Ө.РИНЧИНМЯДАГ

<sup>1</sup> Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.